



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/217

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах,  
ажлын байрны байршил өөрчлөх, тусгай зөвшөөрлийн  
гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.1, 19.3.5, 19.3.8 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 16 дугаар зүйлийн 16.2, 16.2.2, “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ын 2 дугаар хэсгийн 2.6.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2022 оны 4 дүгээр сарын 05-ны хуралдааны шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрөл сунгасан эмийн сан, үүдэн эмнэлгүүдийн нэрсийг нэгдүгээр хавсралт, мансууруулах эмээр үйлчлэх зөвшөөрөл олгосон эмийн сангийн нэрсийг хоёрдугаар хавсралт, тусгай зөвшөөрөл шинээр олгосон үүдэн эмнэлэг, эмийн сангийн нэрсийг гуравдугаар хавсралт, ажлын байрны байршил өөрчилж буй байгууллагын нэрсийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батласугай.

2. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй “Соддент” шүдний үүдэн эмнэлгийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулсугай.

3. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй “Мандах ирээдүй” мэдрэлийн үүдэн эмнэлгийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээн дээрх нэрийг өөрчилсүгэй.

4. Дээрх үүдэн эмнэлэг болон эмийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгийн газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны  
... дугаар сарын ...-ны өдрийн  
захирамжийн нэгдүгээр хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг сунгасан байгууллагуудын нэрс


№	Тусгай зөвшөөрөл эзэмших байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийг сунгасан хугацаа
1	Бор-өндөр сумын "Цэгцүүлэн дом" ӨЭМТ	3 жил
2	Хэрлэн сумын "Монос Хэнтий" ХХК-ний эмийн сан	1 жил
3	Хэрлэн сумын "Онош" лаборатори	3 жил
4	Дадал сумын "Амирлангуй арвижих" ХХК-ний эмийн сан	1 жил
5	Баян-Овоо сумын "Алтан талын хишиг" эмийн сан	1 жил
6	Хэрлэнбаян-Улаан тосгоны "Ар цэнхэр" эмийн сан	1 жил
7	Цэнхэрмандал сумын "Өргөн баян хангай" эмийн сан	1 жил
8	Дэлгэрхаан сумын "Эрдэнэ бодис" эмийн сан	1 жил
9	Батноров сумын "Болор тайван" ХХК-ний эмийн сан	3 жил
10	Жаргалтхаан сумын "Хишиг тухан" эмийн сан	3 жил
11	Өмнөдэлгэр сумын "Далерон" эмийн сан	1 жил
12	Баянмөнх сумын "Мөнхрөх гэрэлт тун" эмийн сан	1 жил
13	Баян-Адарга сумын "Ононфарм" эмийн сан	3 жил
14	Баян-Овоо сумын "Гүрэм оюут" эмийн сан	1 жил



Аймгийн Засаг даргын 2022 оны  
А/217 09 дугаар сарын 18-ны өдрийн  
захирамжийн хоёрдугаар хавсралт

Мансууруулах эмээр үйлчлэх  
зөвшөөрөл олгосон эмийн сангийн нэрс

№	Тусгай зөвшөөрөл эзэмших байгууллагын нэр
1	Баян-Адарга сумын "Ононфарм" эмийн сан
2	Норовлин сумын "Улз тун" эмийн сан
3	Өмнөдэлгэр сумын "Далерон" эмийн сан
4	Бор-Өндөр сумын "ЭЭС БОДЬ" ХХК-ний эмийн сан
5	Хэрлэнбаян-Улаан тосгоны "Ар цэнхэр" эмийн сан
6	Жаргалтхаан сумын "Хишиг тухан" эмийн сан
7	Батноров сумын "Болор тайван" ХХК-ний эмийн сан
8	Батширээт сумын "Домч онон" эмийн сан
9	Дэлгэрхаан сумын "Эрдэнэ бодис" эмийн сан
10	Дархан сумын "Мөнхбилэг мөнх" эмийн сан
11	Цэнхэрмандал сумын "Өргөн баян хангай" эмийн сан
12	Биндэр сумын "Биндэр амгалант" эмийн сан
13	Баянмөнх сумын "Мөнхрөх гэрэлт тун" эмийн сан




Аймгийн Засаг даргын 2022 оны  
дугаар сарын 18-ны өдрийн  
захирамжийн гуравдугаар хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрөл шинээр олгосон байгууллагын нэрс

№	Тусгай зөвшөөрөл эзэмших байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл олгосон хугацаа
1	Хэрлэн сум "Хэнтий Хэрлэн" ХХК-ний "Арвад шагай" эмийн сан	1 жил
2	Хэрлэн сум "Баясгалант дэлхий энх оршихуй" ХХК-ний "Жаргалан" мэдрэлийн үүдэн эмнэлэг	1 жил





Аймгийн Засаг даргын 2022 оны  
дугаар сарын 18-ны өдрийн  
захирамжийн дөрөвдүгээр хавсралт

Үйл ажиллагаа явуулж буй ажлын байрны  
байршил өөрчлөгдсөн байгууллагууд

№	Тусгай зөвшөөрөл эзэмших байгууллагын нэр	Өөрчлөгдсөн байршил
1	Хэрлэн сум "Хэнтий Хэрлэн" ХХК-ний "Байгаль" эмийн сан	Хэрлэн сум 1 дүгээр баг, Ж-36 байр
2	Хэрлэн сум "Хайрхан тун" ХХК-ний "Ази фарм" эм ханган нийлүүлэх байгууллага	Хэрлэн сум 4 дүгээр баг, Б-65
3	Хэрлэн сум "Бумбат" эмийн сан	Хэрлэн сум 3 дугаар баг, Тээвэрчдийн 1-1